



ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
СТАТИТИКИЙН ХЭЛТЭС

МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТООЛЛОГО



2025 он

ОРШИЛ

Дэлхийн олон улс орнуудын нэгэн адил манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбарын нэг юм.

Монгол Улсын үндсэн хуулинд мал сүргийг үндэсний баялаг мөн гэж томъёолж, мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

Монгол Улсын "Статистикийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 3 а, 3 б заалт, 7 дугаар зүйлийн 7.1 в, 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1667 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын 2025 оны А/550 дугаар захирамжаар Үндэсний Статистикийн Хорооноос гаргасан тооллого явуулах удирдамж, зааврын дагуу 2025 оны Мал, тэжээвэр амьтдын тооллогыг 12 сарын 07-ноос 17-ны өдрүүдэд дүүргийн хэмжээнд амжилттай зохион байгуулж явууллаа.

Энэхүү танилцуулгад орж байгаа статистикийн үзүүлэлтүүдийг дүүргийн мал, тэжээвэр амьтдын 2025 оны тооллогын мэдээллийг боловсруулж, Үндэсний Статистикийн хорооноос баталж зөвшөөрсөн, олон улсын стандартад нийцсэн аргачлалын дагуу тооцож, үр дүнг гаргалаа.

ТОВЧ ТАЙЛБАР, ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Малтай өрх: Малчин өрхөөс гадна малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрхийг хэлнэ.

Малчин өрх: Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эхүүсвэр болж байгаа өрхийг хэлнэ.

Малчид: Жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Бодод шилжүүлэх коэффициент:

1 Адуу, үхэр = 1 бод, 1 тэмээ = 1.5 бод,

6 хонь = 1 бод, 8 ямаа = 1 бод

Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ = 5 хонь, 1 адуу = 7 хонь, 1 үхэр = 6 хонь

1 хонь = 1 хонь, 1 ямаа = 0.9 хонь

Нас гүйцсэн мал: Малын төрөл бүр дээр сүүлчийн 2 насны малыг хэлнэ.

Тэмээ- 4 настай, 5 ба түүнээс дээш настай

Адуу- 3 настай, 4 ба түүнээс дээш настай

Үхэр- 2 настай, 3 ба түүнээс дээш настай

Бог мал – тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал:

Тэмээ-Өнгөрсөн жилийн төл, 2, 3 настай

Адуу- Өнгөрсөн жилийн төл, 2 настай

Үхэр- Өнгөрсөн жилийн төл

Төл мал: Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч: Малын төрөл бүр дээр сүүлийн 2 насны эх малыг хэлнэ.

Малын тоо, толгойн өсөлт: Оны эцсийн малаас оны эхний малыг хасаж гаргана.

Харьцангуй үзүүлэлтийг гаргахдаа оны эцсийн малын тоо гэх нийт малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ. Малын өсөлтийн орлого тал нь төл бойжилт, зарлага тал нь хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол болно.

Төллөлтийн хувь: Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100 –гаар үржүүлнэ.

Бойжилтын хувь: Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100 –гаар үржүүлнэ. 100 эхээс бойжуулсан төл: Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо: Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулан гаргана. 1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур - 20-25 Азарга - 12-15 Бух - 35-45 Хуц, ухна - 25-30

Малын зүй бус хорогдол: Өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариуллага, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг оруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь: Зүй бусаар хорогдсон малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

Малын хэрэглээний зарлага:

1. Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч гаргана.

2. Хүнсний хэрэглээний малын тоо= Алдсан мал+Зах зээлд борлуулсан+Аж ахуйн дотоод хэрэглэсэн+(Бусдад шилжүүлсэн – Худалдаж авсан, шилжиж ирсэн).

Бусдад шилжүүлсэн>=Худалдаж авсан, шилжиж ирсэн

Учир нь худалдаж авсан эсвэл шилжиж ирсэн нэг хэсэг малаа идсэн байж болно. Идээгүй тохиолдолд тэнцэж байх учиртай.

Малын хашааны хангамж: Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулан гаргана. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, бог малынхыг гаргахдаа богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулна.

Тэжээл хангамж: Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан гаргана. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлэн тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент: Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлэн тэжээлийн хангамжийг гаргадаг.

Үүний тулд дараахь итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

Хадлан өвс	0.45
Таримал тэжээл	0.35
Даршны ургамал	0.25
Гартэжээл, хужир шүү	1.0
Төмс ногооны хаягдал	0.22
Үр тарианы хаягдал	0.9
Лай	0.4
Сүрэл	0.25


Малын тэжээлийн ангилал: Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.



МАЛТАЙ ӨРХ, МАЛЧДЫН ТОО, ТЭДНИЙ СОЁЛ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Малын тоо, бүтэц: Хан-Уул дүүрэгт 2025 оны мал тооллогоор нийт 56651 толгой мал тоологдсон нь 2024 оноос 7188 (14.5%) толгой малаар өссөн байна. Нийслэлийн хэмжээнд 2025 онд 423592 толгой мал тоологдсон бөгөөд 13.4 хувийг Хан-Уул дүүргийн мал эзэлж байна.

ЗУРАГ 1. ДҮҮРГИЙН НИЙТ МАЛЫН ТОО, оноор



Малын тоог таван төрлөөр өмнөх онтой харьцуулахад, тэмээ 4 толгойгоор (14.3%) адуу 3646 толгойгоор (18.7%), үхэр 1050 толгойгоор (8.0%), хонь 1511 толгойгоор (16.8%), ямаа 977 толгойгоор (12.6%) тус тус өссөн байна. Иргэдийн хувийн мал 55913 толгой болж, өмнөх оноос 6826 толгойгоор өссөн бол аж ахуйн нэгж, байгууллагын мал 738 болж өмнөх оноос 362 толгойгоор өссөн байна.

ХҮСНЭГТ 1. МАЛЫН ТОО, төрлөөр

Малын төрөл	2020	2021	2022	2023	2024	2025	Өсөлт, бууралт	
							Тоо	Хувь
Малын тоо, бүгд	46 090	42 867	46 068	52 083	49 463	56 651	7 188	14.5
Тэмээ	7	11	19	8	28	32	4	14.3
Адуу	11 960	12 597	15 422	18 052	19 529	23 175	3 646	18.7
Үхэр	11 900	11 214	12 293	12 481	13 158	14 208	1 050	8.0
Хонь	10 231	9 626	9 158	10 867	8 990	10 501	1 511	16.8
Ямаа	11 992	9 419	9 176	10 675	7 758	8 735	977	12.6
Хонин толгойд шилжүүлснээр*	176179	173621	199223.4	221764.5	231763.2	265995.5	34232.3	14.8

* Таван хошуу малыг хонин толгойд шилжүүлэх коэффициент: 1 тэмээ: 5 хонь, 1 адуу: 7 хонь, 1 үхэр: 6 хонь, 1 хонь: 1 хонь, 1 ямаа: 0.9 хонь

2025 онд Хан-Уул дүүргийн 12-р хорооны мал 9.8 хувиар, 13-р хорооных 15.7 хувиар, 14-р хорооны мал 14.6 хувиар тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 2. МАЛЫН ТОО, хороогоор

Хороо	2024	2025	Үүнээс: малын төрлөөр					Өсөлт, бууралт, хувь
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	
Дүн	49 463	56 651	32	23 175	14 208	10 501	8 735	14.5
12-р хороо	3743	4111	3	1474	1642	273	719	9.8
13-р хороо	13 392	15 498	-	3827	6630	2612	2429	15.7
14-р хороо	32 328	37042	29	17874	5936	7616	5587	14.6

Дүүргийн хэмжээнд тоологдсон малын тоогоор 37042 толгой малаар 14-р хороо тэргүүлсэн бол хамгийн цөөн малтай нь 12-р хороо 4111 толгой малтай байна. 2025 онд нийт мал сүргийн 34.0 хувийг бог мал, 66.0 хувийг бод мал эзэлж байна. Нийт мал сүргийн бүтцэд таван төрлийн малын эзлэх хувийн жинг төрөл тус бүрээр нь дараах хүснэгтэд харууллаа.

ХҮСНЭГТ 3. НИЙТ МАЛД ЭЗЛЭХ ХУВИЙН ЖИН, МАЛЫН ТӨРЛӨӨР

Нийт мал	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он
	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
Тэмээ	0.01	0.008	0.015	0.02	0.04	0.01	0.06	0.06
Адуу	17.3	19.6	26.0	29.4	33.5	34.6	39.5	41.0
Үхэр	33.8	30.7	25.8	26.1	26.7	24.0	26.6	25.1
Хонь	25.8	26.8	22.2	22.5	19.9	20.9	18.2	18.5
Ямаа	23.0	22.892	26.0	22.0	19.9	20.5	15.7	15.4

Нийт мал сүргийн 0.06 хувийг тэмээ, 41.0 хувийг адуу, 25.1 хувийг үхэр, 18.5 хувийг хонь, 15.4 хувийг ямаа эзэлж байна. Малын нийт дүнд эзлэх хувийн жинг өмнөх онуудтай харьцуулахад адуу, хонь эзлэх хувийн жин нэмэгдэж, үхэр, ямааны эзлэх хувийн жин багассан байна. Бог малын бүтцийн хувьд нийт бог малын 54.6 хувийг хонин сүрэг, 45.4 хувийг ямаан сүрэг эзэлж байна.

Малтай өрх, малчдын тоо: Хан-Уул дүүрэгт 2025 оны мал тооллогоор нийт 56651 толгой мал тоологдсон нь 2024 оноос 7188 (14.5%) толгой малаар өссөн байна. 2025 оны мал тооллогын дүнгээр хувийн малтай 823 өрх, үүний дотор 302 малчин өрх мал аж ахуй эрхэлж байна. Өнгөрсөн оноос малтай өрхийн тоо 16 өрхөөр, малчин өрхийн тоо 35 өрхөөр өссөн байна.


ХҮСНЭГТ 4. МАЛТАЙ ӨРХ, МАЛЧДЫН НАСНЫ БҮЛГЭЭР

он	Малтай өрхийн тоо	Малчин өрхийн тоо	Түүний ам бүлийн тоо	Малчдын тоо	16 хүртэлх насны	Насны бүлэг			Нийт малчдаас эмэгтэй
						16-34 насны	35-54 насны эм, 35-59 насны эр	55 ба дээш эм, 60-аас дээш насны эр	
2007	984	293	947	644	-	223	250	171	208
2008	854	300	1098	605	-	212	235	164	192
2009	933	178	547	178	-	29	106	43	62
2010	937	176	609	319	-	58	164	97	98
2011	877	287	375	421	-	19	210	112	158
2012	840	56	201	110	-	31	63	16	50
2013	809	100	356	185	-	42	125	18	85
2014	728	104	364	209	-	59	122	28	100
2015	816	106	385	216	-	57	140	19	95
2016	836	206	704	389	-	85	252	52	164
2017	809	153	610	281	6	79	163	33	108
2018	700	182	602	288	-	75	185	28	117
2019	674	232	851	352	-	77	245	30	145
2020	729	210	757	293	-	55	212	26	105
2021	764	219	800	318	-	62	245	11	129
2022	802	258	950	368	-	67	275	26	139
2023	789	242	922	338	-	67	256	15	124
2024	807	267	1013	365	-	71	269	25	124
2025	823	302	1208	454	-	73	322	59	187

Малчдыг насны бүлгээр авч үзвэл 16.1 хувь нь 15-34 насны, 70.9 хувь нь 35-аас 54 насны эмэгтэй, 35-59 насны эрэгтэй, 13.0 хувь нь эмэгтэй 55, эрэгтэй 60-аас дээш насны хүмүүс байна. Нийт малчдын 187 буюу 41.2 хувь нь эмэгтэй малчид байна.

ЗУРАГ 2.

МАЛЧДЫН ТОО, НАСНЫ БҮЛГЭЭР



Дүүргийн малчин өрх, малчдын тоог өнгөрсөн онтой харьцуулахад малчин өрхийн тоо 35 өрх (13.1%), малчдын тоо 89 хүнээр (24.4%) нэмэгдсэн байна.

Малчин өрхийн 57.9 хувийг цахилгаан эх үүсвэртэй, 59.6 хувийг телевизортой өрх эзэлж байна.

"Амины мал"-ын тоо: Иргэдийн хувийн өмчийн малын тоо 2025 онд 55913 толгой болж, нийт малын 98.7 хувийг эзэлж байна. Тоологдсон адууны 99.3 хувь, үхрийн 95.9 хувь, хонь, ямаа 100.0 хувь айл өрхийн мал эзэлж байна.

ХҮСНЭГТ 5.

МАЛТАЙ ӨРХИЙН ТОО, МАЛЫН БҮЛЭГЛЭЛТЭЭР, 2025 он

Малын бүлэглэлт	Малтай өрхийн тоо	Ам бүлийн тоо	Амины малын тоо	Үүнээс: малын төрлөөр				
				Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Дүн	823	3 028	55 913	32	23 020	13 625	10 501	87 35
10 хүртэл	181	617	1 116	-	260	853	2	1
11-30	205	706	4 087	2	1 497	2 299	119	170
31-50	139	489	5 511	-	2 887	2 381	173	70
51-100	156	623	11 074	5	5 993	3 775	588	713
101-200	82	337	11 567	2	6 970	2 238	1 183	1 174
201-500	49	209	14 905	19	4 210	1 625	5 048	4 003
501-999	9	36	5 586	4	1 155	387	2 168	1 872
1000-1499	2	11	2 067	-	48	67	1 220	732
1500-2000	-	-	-	-	-	-	-	-

Дүүргийн малтай нэг өрхөд 60.8 толгой мал, бодод шилжүүлснээр 43.1 толгой мал ногдож байна. Малтай өрхийн ам бүлийн нэг хүнд 16 толгой мал, бодод шилжүүлснээр 11 толгой мал ногдож байна.

Мал төллөлт, төл бойжилт: 2025 онд 16665 хээлтэгч мал төллөж, 16665 төл гарсны 16460 төл (98.8%) нь бойжиж байна. Бойжсон төлийн тоо өмнөх оноос 4313 толгойгоор (35.5%) өссөн.

ЗУРАГ 3.

БОЙЖУУЛСАН ТӨЛ, оноор



Бойжуулсан нийт төлийн 29.8 хувийг унага, 34.5 хувийг тугал, 18.8 хувийг хурга, 16.9 хувийг ишиг эзэлж байна.

ХҮСНЭГТ 6. ТӨЛ БОЙЖИЛТ, төрлөөр

	2024	2025	Үүнээс:				
			Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
Гарсан төл	12 979	16 665	-	4 952	5 757	3 131	2 825
Бойжсон төл	12 147	16 460	-	4 897	5 688	3 094	2 781
Хорогдсон төл	832	205	-	55	69	37	44
Бойжилтын хувь	93.6	98.8	-	98.9	98.8	98.8	98.4

2025 оны мал тооллогоор нийт 16665 гарсан төлийн 205 (1.2%) толгой нь хорогдож, төл бойжилт 98.8 хувьтай байна. Хорогдсон төл малын тоо 2024 оныхоос 627 толгойгоор буурсан. Нийт хорогдсон төлийн 26.8 хувийг унага, 33.7 хувийг тугал, 18.0 хувийг хурга, 21.5 хувийг ишиг эзэлж байна.

ХҮСНЭГТ 7. ТӨЛ БОЙЖИЛТ, ТӨЛИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, төрлөөр

Төрөл	Төллөсөн хээлтэгч	Гарсан төл	Хорогдсон төл	Бойжсон төл	Худалдаж авсан	Шилжиж ирсэн	Худалдсан	Шилжүүлсэн
Бүгд	16 665	16 665	205	16 460	822	1 357	3 524	845
Ботго	-	-	-	-	-	-	-	-
Унага	4 952	4 952	55	4 897	58	729	364	333
Тугал	5 757	5 757	69	5 688	143	170	2 212	233
Хурга	3 131	3 131	37	3 094	444	166	460	128
Ишиг	2 825	2 825	44	2 781	177	292	488	151

2025 онд нийт 16460 төл бойжуулсан, 822 төл бусдаас худалдан авсан, 1357 төл шилжиж ирсэн байна. Мөн 3524 төлийг бусдад худалдаж, 845 төлийг шилжүүлсэн байна. 2025 онд худалдсан төлийг төрлөөр нь авч үзвэл: унага 364 толгой, тугал 2212 толгой, хурга 460 толгой, ишиг 488 толгой төл худалджээ.

Бэлэн тоологдсон төл : 2025 оны мал тооллогоор бэлэн тоологдсон төлийн тоо 14265 толгой болж өнгөрсөн оныхоос 4294 толгой (43.1%) төлөөр нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 8. БЭЛЭН ТООЛОГДСОН ТӨЛ, төрлөөр

Төрөл	2019	2020	2021	2022	2023	2024	2025	2025/2024	
								хувь	зөрүү
Бүгд	11 841	11 896	9 366	12 162	11 154	9 971	14 265	43.1	4294
Ботго	-	1	5	-	-	20	-	-	-20
Унага	1701	2193	1905	3014	3022	3125	4987	59.6	1862
Тугал	3898	3599	2913	3433	3262	3056	3551	16.2	495
Хурга	3432	3230	2489	3095	2673	2180	3116	42.9	936
Ишиг	2810	2873	2054	2620	2197	1590	2611	64.2	1021

Том малын зүй бус хорогдол: Оны эхний малын 1.1 хувьтай тэнцэх 524 толгой том мал зүй бусаар хорогдож, өмнөх оноос хорогдол 4490 толгойгоор буурсан. Хорогдсон нийт малын 26.3 хувийг адуу, 24.4 хувийг үхэр, 19.5 хувийг хонь, 29.8 хувийг ямаа эзэлж байна. Том малын зүй бус хорогдлын 9 толгой (1.7%) мал өвчнөөр хорогджээ.

ХҮСНЭГТ 9.

ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ

Үзүүлэлт	2024	2025	Үүнээс:				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Хорогдсон том мал	5014	524	-	138	128	102	156
Үүнээс: Өвчнөөр хорогдсон	4	9	-	5	1	2	1

Малын хэрэглээний орлого зарлага: 2025 онд оны эхний нийт малын 1614 (3.3%) толгой малыг хүнсний хэрэглээнд зарцуулсан байна. Хүнсэнд зарцуулсан малын 31.5 хувийг хонь, 17.4 хувийг ямаа, үлдсэн 51.1 хувийг бод мал эзэлж байна.

ХҮСНЭГТ 10.

МАЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ОРЛОГО, ЗАРЛАГА, ТӨРЛӨӨР

Төрөл	Орлого			Хасагдсан				
	Худалдаж авсан	Шилжиж ирсэн	Бэлэн тоологдсон төл	Шилжүүлсэн	Алдсан, кулгайлагдсан олдохгүй байгаа	зах зээлд борлуулсан	Хүнсэнд хэрэглэсэн	Зүй бус хорогдол
Дүн	2 809	5 215	142 65	5 504	84	7 375	1 614	524
Тэмээ	2	4	-	-	-	2	-	-
Адуу	920	2672	4 987	2 956	18	1 583	238	138
Үхэр	943	936	3 551	1 540	40	2 085	587	128
Хонь	460	827	3 116	479	19	1 784	508	102
Ямаа	484	776	2 611	529	7	1 921	281	156

Дээрх хүснэгтээс харахад энэ жилийн малын орлого талд тооллогоор худалдаж авсан 2809 толгой, бэлэн тоологдсон төл 14265 толгой, шилжиж ирсэн 5215 толгой мал байна. Харин шилжүүлсэн 5504 толгой мал, зүй бусаар 524 толгой мал хорогдсон, хүнсэнд хэрэглэсэн 1614 толгой мал, 7375 толгой малыг зах зээлд борлуулсан нь зарлага талын үзүүлэлтийг бүрдүүлж байна.

ХҮСНЭГТ 11.

МАЛЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТӨД НӨЛӨӨЛСӨН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025	2025/2024	
						тоо	Хувь
Бэлэн тоологдсон төл	9366	12162	11154	9971	14265	4294	43.1
Том малын зүй бусын хорогдол	3000	596	1679	5014	524	-4490	-89.5
Хээлтэгч малын тоо	20446	20878	25377	24437	26765	2328	9.5
Хээл хаясан хээлтэгч	1066	359	854	1742	331	-1411	-81.0
Сувайрсан хээлтэгч	5271	3470	4478	6596	5977	-619	-9.4

2025 онд хээлтэгч малын тоо өнгөрсөн оноос 9.5 хувиар өсөж, том малын зүй бусын хорогдол 89.5 хувиар, хээл хаясан хээлтэгч 81.0 хувиар, сувайрсан хээлтэгч 9.4 хувиар тус тус буурсан байна.

Малын хээл хаялт, сувайралт: 2025 онд оны эхний хээлтэгч малын 25.8 хувьтай тэнцэх хээлтэгч мал төл өгөөгүй ба үүний 5977 эх мал сувайрсан, 331 эх мал хээл хаясан байна. Энэ нь өмнөх оноос сувайрсан мал 619 толгойгоор, хээл хаясан мал 1411 толгойгоор буурсан байна.

ХҮСНЭГТ 12.

СУВАЙРСАН БОЛОН ХЭЭЛ ХАЯСАН МАЛ, төрлөөр

Төрөл	Төл өгөөгүй хээлтэгч мал			Үүнээс:					
				Сувайрсан			Хээл хаясан		
	2023	2024	2025	2023	2024	2025	2023	2024	2025
Бүгд	5 332	8 338	6 308	4 478	6 596	5 977	854	1742	331
Ингэ	-	-	-	-	-	-	-	-	-
Гүү	2126	3074	2394	1835	2550	2335	291	524	59
Үнээ	1425	1724	1504	1350	1614	1487	75	110	17
Эм хонь	978	1729	1334	744	1261	1176	234	468	158
Эм ямаа	803	1811	1076	549	1171	979	254	640	97

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо: Дүүргийн нийт мал сүргийн 14265 (25.2%) нь төл мал, 26765 (47.2%) нь хээлтэгч мал, 1039 нь хээлтүүлэгч мал байна. Малын үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох ёстой байхад дүүргийн хувьд нэг хээлтүүлэгчид дунджаар 119 эм хонь, 108 эм ямаа ногдож, хээлтүүлгийн тохироо алдагдсан байна.

ХҮСНЭГТ 13.

ХЭЭЛТҮҮЛЭГЧ МАЛЫН ТОО

Төрөл	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	Өсөлт, бууралт /тоо/
Бүгд	535	537	620	773	795	968	999	991	1039	48
Буур	-	-	-	-	-	-	-	4	1	-3
Азарга	325	350	424	557	593	709	750	748	831	83
Бух	106	110	110	110	113	123	120	130	120	-10
Хуц	56	41	47	52	46	61	70	66	46	-20
Ухна	48	36	39	54	43	75	59	43	41	-2

Хээлтэгч мал: 2025 оны мал тооллогоор 26765 толгой хээлтэгч мал тоологдсон нь өнгөрсөн оноос 2328 толгой (9.5%) малаар өссөн байна.


ХҮСНЭГТ 14.

ХЭЭЛТЭГЧ МАЛ, төрлөөр

Төрөл	2020	2021	2022	2023	2024	2025	Өсөлт, бууралт	
							тоо	хувь
Бүгд	20736	20446	20878	25377	24437	26765	2328	9.5
Ингэ	1	-	-	-	-	-	-	-
Гүү	3841	4494	5409	6743	7797	8830	1033	13.2
Үнээ	5711	5983	6423	6742	7520	8050	530	7.0
Эм хонь	5132	4942	4408	6054	4990	5469	479	9.6
Эм ямаа	6051	5027	4638	5838	4130	4416	286	6.9

ЗУРАГ 5.

ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО



2025 онд дүүргийн нийт малын 47.2 хувийг хээлтэгч мал эзэлж байна. Үүнд: адуун сүргийн 38.1 хувь, үхэр сүргийн 56.7 хувь, хонин сүргийн 52.1 хувь, ямаан сүргийн 50.5 хувийг хээлтэгч мал эзэлж байна.

Бэлтгэсэн хадлан тэжээл: Дүүргийн хэмжээнд 2025 онд 17564.4 тонн хадлан, гар тэжээл 4903.8 тонн, хужир шүү 317.2 тонныг тус тус бэлтгэсэн байна. 2024 онтой харьцуулахад хадлан 5405.9 тонн (44.5%), хужир шүү 45.7 тонн (16.8%), гар тэжээл 2871.6 тонноор буюу 2.4 дахин нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 15. БЭЛТГЭСЭН ХАДЛАН ТЭЖЭЭЛ, тн

Бэлтгэсэн хадлан тэжээл	2020	2021	2022	2023	2024	2025	Өсөлт, бууралт
Хадлан	6 664.2	12 387.9	11 126.7	10 634.8	12 158.5	17 564.4	5 405.9
Гар тэжээл	1 235.5	1 098.2	1 163.6	1 399.3	2 032.2	4 903.8	2 871.6
Хужир шүү	146.6	353.6	287.4	264.3	271.5	317.2	45.7

2025 оны мал, тэжээвэр амьтдын тооллогоор 218 худаг, 935 малын хашаа тоологдсон нь 2024 онтой харьцуулахад худаг 25.6 хувиар, малын хашаа 27.3 хувиар буурсан байна.

Тэжээвэр амьтад: Мал, тэжээвэр амьтдын 2025 оны тооллогоор 33 өрх, 11 аж ахуйн нэгж, байгууллагын 265 гахай, гурван сая нэг зуун тавин мянган загас, 469613 шувуу, үүнээс 469561 тахиа, цацагт хяруул 11, галуу 21, илжиг 1 тус тус тоологдсон байна. Өмнөх онтой харьцуулахад шувуу болон тахианы тоо 8.1 хувиар буурсан бол гахайн тоо 81.5 хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 16. ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024	2025
Гахай	3 610	4 037	3 785	848	1437	265
Шувуу	483 300	445 390	611 826	529 090	511 052	469 613
Үүнээс: тахиа	482 860	444 701	611 724	529 011	511 027	469 561
Зөгийн бүл	-	-	4	-	-	-

Гахай, шувуу тэжээдэг иргэд, аж ахуйн нэгжүүд 2025 онд 1.5 тонн гахайн мах, 171.1 тонн шувууны мах, 115.3 сая ширхэг өндөг нийт 54726.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Гэрийн тэжээвэр муур, нохой: Хан-Уул дүүргийн 25 хороонд гэрийн тэжээвэр 4176 нохой, 345 муур байна. Бүртгэлийн дүнг өмнөх оны дүнтэй харьцуулахад нохойн тоо 192 (4.8%), муурны тоо 41 (13.5%)-ээр өссөн байна.

ХҮСНЭГТ 17.

ТЭЖЭЭВЭР НОХОЙ, МУУРНЫ ТОО, хороогоор

Хороо	Нохой			Муур		
	2024	2025	Өсөлт, бууралт	2024	2025	Өсөлт, бууралт
Нийт	3 984	4 176	104.8	304	345	13.5
1-р хороо	33	33	-	5	5	-
2-р хороо	18	18	-	6	6	-
3-р хороо	27	27	-	11	11	-
4-р хороо	208	93	-55.3	3	8	2.6*
5-р хороо	279	219	-21.5	7	4	-42.8
6-р хороо	325	272	-16.3	5	5	-
7-р хороо	181	206	13.8	7	6	-14.3
8-р хороо	552	505	-8.5	11	9	-18.2
9-р хороо	504	527	4.6	1	4	4.0*
10-р хороо	250	246	-1.6	31	30	-3.2
11-р хороо	13	13	-	3	7	2.3*
12-р хороо	421	484	15.0	18	18	-
13-р хороо	392	397	1.3	62	58	-6.4
14-р хороо	274	598	2.2*	20	42	2.1*
15-р хороо	44	43	-2.3	8	8	-
16-р хороо	289	254	-12.1	13	12	-7.7
17-р хороо	27	48	77.8	23	25	8.7
18-р хороо	19	19	-	9	9	-
19-р хороо	43	53	23.2	14	15	7.1
20-р хороо	11	6	-45.4	15	21	40.0
21-р хороо	10	37	3.7*	3	11	3.6*
22-р хороо	5	5	-	4	4	-
23-р хороо	23	20	-13.0	9	8	-11.1
24-р хороо	24	41	70.8	14	17	21.4
25-р хороо	12	12	-	2	2	-

*дах -дахин

Тэжээвэр нохойны тоог хороогоор авч үзвэл 7, 9, 12, 13, 14, 17, 19, 21, 24-р хорооны нохойны тоо 1.3 хувиас дээш өссөн бол бусад хорооны нохойны тоо буурсан байна. Харин 1, 2, 3, 11, 18, 22, 25 дугаар хорооны нохойны тоо өмнөх оны түвшинд байна.

Нийт бүртгэгдсэн тэжээвэр нохойны 14.3 хувь нь 14 дүгээр хороонд, 12.6 хувь нь 9 дүгээр хороонд байна.

Тэжээвэр муурны тоо 4, 9, 11, 14, 17, 19, 20, 21, 24-р хороонд 7.1 хувиас дээш өссөн, бусад хороонд буурсан. Харин 1, 2, 3, 6, 12, 15, 18, 22, 25 дугаар хорооны муурны тоо өмнөх оны түвшинд байна.

ДҮГНЭЛТ

Хан-Уул дүүрэгт 2025 оны мал тооллогоор нийт 56651 толгой мал тоологдсон нь 2024 оноос 7188 (14.5%) толгой малаар өссөн байна. Малын тоо толгой өсөхөд тэмээ 4 толгой (14.3%), адуу 3646 толгой (18.7%), үхэр 1050 толгой (8.0%), хонь 1511 толгой (16.8%), ямаа 977 толгойгоор (12.6%) тус тус өссөн нь голлон нөлөөлжээ. 2025 онд бог малын бүтцэд нийт бог малын 54.6 хувийг хонин сүрэг, 45.4 хувийг ямаан сүрэг эзэлж байна.

Дүүргийн хэмжээнд малтай 3 хороонд 823 өрх, 12 ААН-ийн нийт 56651 толгой мал тоологдсоныг малын төрөл тус бүрээр авч үзвэл:

- ✓ тэмээ 32
- ✓ адуу 23175
- ✓ үхэр 14208
- ✓ хонь 10501
- ✓ ямаа 8735 толгой байна.

Малын таван төрлөөр өмнөх онтой харьцуулахад тэмээ 4 толгойгоор (14.3%), адуу 3646 толгойгоор (18.7%), үхэр 1050 толгой (8.0%), хонь 1511 толгой (16.8%), ямаа 977 толгойгоор (12.6%) тус тус өссөн байна.

Нийт мал сүргийн 0.06 хувийг тэмээ, 41.0 хувийг адуу, 25.1 хувийг үхэр, 18.5 хувийг хонь, 15.4 хувийг ямаа тус тус эзэлж байна. Нийт малын 47.2 хувийг хээлтэгч мал, 25.2 хувийг төл мал эзэлж байна. 2025 оны мал тооллогоор нийт 16665 төл гарсны 205 (1.2%) толгой нь хорогдож, төл бойжилт 98.8 хувьтай байна.

2025 онд дүүргийн хэмжээнд 33 өрх, 11 аж ахуйн нэгж байгууллагын 265 гахай, 469613 шувуу, үүнээс 469561 тахиа тоологджээ. 2025 оны дүүргийн нохой, муурны бүртгэлээр гэрийн тэжээвэр нохой 4176, муур 345 бүртгэгдсэн байна.

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2026 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр

ХҮСНЭГТ 1. ТЭМЭЭ, ТОЛГОЙ

Хороо	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Дүн	7	1	3	3	7	11	19	8	28	32
11	1	1	-	-	-	-	-	-	-	-
12	-	-	-	-	-	-	-	-	2	3
13	-	-	-	-	2	-	-	-	-	-
14	6	-	3	3	5	11	19	8	26	29

ХҮСНЭГТ 2. АДУУ, ТОЛГОЙ

Хороо	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Дүн	7451	6247	5745	7589	11960	12597	15422	18052	19529	23175
4	12	2	-	-	-	-	-	-	-	-
5	5	6	-	-	-	-	-	-	-	-
6	-	4	-	-	-	-	-	-	-	-
7	162	-	-	-	-	-	-	-	-	-
8	154	109	-	-	-	-	-	-	-	-
9	4	17	-	-	-	-	-	-	-	-
10	67	29	-	-	-	-	-	-	-	-
11	6	-	-	-	-	-	-	-	-	-
12	634	434	843	773	799	833	944	1022	1256	1474
13	1941	1884	1460	1676	2140	2051	2663	2663	2921	3827
14	4466	3762	3442	5140	9021	9713	11815	14367	15352	17874
16	-	-	-	-	-	-	-	-	-	-

ХҮСНЭГТ 3. ҮХЭР, ТОЛГОЙ

Хороо	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Дүн	12274	12616	11231	11845	11900	11214	12293	12481	13158	14208
4	155	134	-	-	-	-	-	-	-	-
5	213	146	-	-	-	-	-	-	-	-
6	55	75	-	-	-	-	-	-	-	-
7	36	-	-	-	-	-	-	-	-	-
8	358	202	-	-	-	-	-	-	-	-
9	196	250	-	-	-	-	-	-	-	-
10	253	220	-	-	-	-	-	-	-	-
11	64	45	-	-	-	-	-	-	-	-
12	2686	2571	2376	2111	2028	1873	1993	1733	1550	1642
13	4321	4820	4754	5174	5259	4944	5753	5575	5993	6630
14	3906	4140	4101	4560	4613	4397	4547	5173	5615	5936
16	31	13	-	-	-	-	-	-	-	-

ХҮСНЭГТ 4. ХОНЬ, ТОЛГОЙ

Хороо	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Дүн	9 958	9 894	8 576	10 336	10 231	9 626	9 158	10 867	8 990	10 501
6	24	36	-	-	-	-	-	-	-	-
7	-	-	-	-	-	-	-	-	-	-
8	164	34	-	-	-	-	-	-	-	-
9	-	299	-	-	-	-	-	-	-	-
10	196	78	-	-	-	-	-	-	-	-
11	-	-	-	-	-	-	-	-	-	-
12	714	1086	576	768	747	371	653	454	302	273
13	3986	3268	2910	2972	2831	2469	2651	2139	2134	2612
14	4874	5093	5090	6596	6653	6786	5854	8274	6554	7616
16	-	-	-	-	-	-	-	-	-	-

ХҮСНЭГТ 5. ЯМАА, ТОЛГОЙ

Хороо	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Дүн	9 170	9 727	7 653	8 866	11 992	9 419	9 176	10 675	7 758	8 735
4	-	-	-	-	-	-	-	-	-	-
5	34	46	-	-	-	-	-	-	-	-
6	-	-	-	-	-	-	-	-	-	-
7	174	100	-	-	-	-	-	-	-	-
8	-	460	-	-	-	-	-	-	-	-
9	161	108	-	-	-	-	-	-	-	-
10	-	-	-	-	-	-	-	-	-	-
11	1685	1848	1270	1254	1315	689	738	503	633	719
12	3380	3583	2889	3031	3494	2626	3592	2886	2344	2429
13	3736	3582	3494	4581	7183	6104	4846	7286	4781	5587
14	-	-	-	-	-	-	-	-	-	-
16	9170	9727	7653	8866	11992	9419	9176	10675	7758	8735

ХҮСНЭГТ 6. ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО төрлөөр, тоо

Он	Бүгд	Ингэ	Гүү	Үнээ	Хонь	Ямаа
2010	15110	1	952	3856	4473	5828
2011	14600	14	976	4280	4220	5110
2012	16910	15	1263	4251	5845	5536
2013	16569	2	1365	4507	5491	5204
2014	19471	8	1685	5146	7137	5495
2015	16572		1591	5585	4833	4563
2016	17812	4	2207	6072	4957	4572
2017	17637	1	1966	6259	4782	4629
2018	16737	1	2158	6105	4434	4039
2019	17716	0	2630	6000	5105	3981
2020	20736	1	3841	5711	5132	6051
2021	20446	-	4494	5983	4942	5027
2022	20878	-	5409	6423	4408	4638
2023	25377	-	6743	6742	6054	5838
2024	24437	-	7797	7520	4990	4130
2025	26765	-	8830	8050	5469	4416

ХҮСНЭГТ 7.

ХЭЭЛТҮҮЛЭГЧ МАЛЫН ТОО, төрлөөр, толгой

Хороо	Бүгд	Үүнээс:				
		Буур	Азарга	Бух	Хуц	Ухна
2007	458	-	168	63	104	122
2008	400	-	117	69	116	120
2009	528	-	201	64	126	137
2010	518	-	319	73	66	60
2011	499	1	290	67	92	49
2012	584	1	318	85	88	92
2013	614	-	346	92	86	90
2014	636	2	331	98	114	91
2015	590	-	345	97	71	77
2016	643	-	418	114	56	55
2017	535	-	325	106	56	48
2018	537	-	350	110	41	36
2019	620	-	424	110	47	39
2020	773	-	557	110	52	54
2021	795	-	593	113	46	43
2022	968	-	709	123	61	75
2023	999	-	750	120	70	59
2024	991	4	748	130	66	43
2025	1039	1	831	120	46	41

ХҮСНЭГТ 8.

БОЙЖСОН ТӨЛ, төрлөөр, толгой

Он	Бүгд	Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
2007	11427	5	205	2465	3922	4830
2008	12492	-	271	2108	4861	5252
2009	14069		351	2242	5225	6251
2010	5630		286	2454	1632	1258
2011	11443	5	620	2850	3569	4399
2012	12073	5	825	3185	3984	4074
2013	15805	6	937	3578	5564	5720
2014	13945		929	3641	4509	4866
2015	15988	4	1002	4103	5835	5044
2016	13181	1	1211	4341	4081	3547
2017	14180	2	1469	5038	4073	3598
2018	11044	-	931	4055	3327	2731
2019	11841	-	1701	3898	3432	2810
2020	12025	-	1703	4373	3181	2768
2021	11130	-	1796	3490	3308	2536
2022	14547	-	3010	4378	3745	3414
2023	16716	-	3553	4678	4021	4464
2024	12147	-	3033	4751	2272	2091
2025	16460	-	4897	5688	3094	2781

ХҮСНЭГТ 9.

ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, төрлөөр, толгой

Он	Бүгд	тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа
2007	122	-	4	38	42	38
2008	247	-	6	121	51	69
2009	166	-	17	37	44	68
2010	20754	-	862	1373	8380	10139
2011	249	-	17	116	48	68
2012	165	-	3	74	44	44
2013	231	-	20	89	72	50
2014	293	-	9	89	63	132
2015	552	-	36	152	120	244
2016	751	-	83	281	187	200
2017	1070	-	142	395	280	253
2018	1775	-	287	432	477	579
2019	383	-	88	103	104	88
2020	1323	-	98	300	535	390
2021	3000	-	456	399	1071	1074
2022	596	-	96	119	125	256
2023	1679	2	327	603	279	468
2024	5014	-	822	554	1775	1863
2025	524	-	138	128	102	156

ХҮСНЭГТ 10.

ХЭЭЛ ХАЯСАН ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО, ТОЛГОЙ

Он	Бүгд	Гүү	Үнээ	Эм хонь	Эм ямаа
2007	353	45	23	170	115
2008	451	29	55	112	255
2009	518	14	66	128	310
2010	1034	39	79	373	543
2011	245	28	60	75	82
2012	373	16	42	130	185
2013	349	23	34	185	107
2014	367	17	31	179	140
2015	233	22	30	69	112
2016	762	70	57	254	381
2017	1936	277	554	649	456
2018	1084	260	186	213	425
2019	519	40	75	250	154
2020	450	74	66	214	96
2021	1066	284	105	304	373
2022	359	63	53	86	157
2023	854	291	75	234	254
2024	1742	524	110	468	640
2025	331	59	17	158	97

ХҮСНЭГТ 11.

СУВАЙРСАН ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО, ТОЛГОЙ

Он	Бүгд	Ингэ	Гүү	Үнээ	Эм хонь	Эм ямаа
2007	1637	1	45	261	502	828
2008	1788	1	55	685	247	800
2009	2329	1	82	671	620	955
2010	1478		137	475	321	545
2011	1089		136	331	253	369
2012	1544	4	204	525	249	562
2013	1234	1	202	501	334	196
2014	2289	1	370	619	748	551
2015	2155		309	763	609	474
2016	2710	1	436	1178	436	659
2017	2313	-	405	946	460	502
2018	4531	-	776	1549	1101	1105
2019	2800	-	535	918	607	740
2020	3084	-	707	888	747	742
2021	5271		1238	1564	974	1495
2022	3470	-	1136	1118	578	6383
2023	4478	-	1835	1350	744	549
2024	6596	-	2550	1614	1261	1171
2025	5977	-	2335	1487	1176	979

ХҮСНЭГТ 12.

МАЛТАЙ ӨРХИЙН БҮЛЭГЛЭЛТ, МАЛЫН ТООНЫ БҮЛГЭЭР

Малын тооны бүлэг	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Дүн	836	809	700	415	729	764	802	789	807	823
10 хүртэл	330	328	267	105	200	224	219	196	192	181
11-30	249	249	201	127	209	222	228	220	223	205
31-50	90	70	87	58	99	112	113	119	145	139
51-100	90	85	80	70	114	115	138	130	121	156
101-200	37	35	34	26	63	56	60	67	76	82
201-500	30	32	20	20	30	24	35	47	41	49
501-999	8	8	9	7	11	8	8	9	9	9
1000-1499	1	1	1	1	2	3	1	1	-	2
1500-2000	1	1	1	1	1	-	-	-	-	-

ХҮСНЭГТ 13.

МАЛТАЙ БОЛОН МАЛЧИН ӨРХИЙН ТОО

он	Малтай өрх	Үүнээс:Малчин өрх	Малчдын тоо	Үүнээс:Эмэгтэй
2006	926	124	210	41
2007	984	293	644	208
2008	851	300	605	192
2009	933	178	3187	547
2010	1034	179	324	98
2011	877	283	648	274
2012	956	56	110	50
2013	809	100	185	85
2014	832	104	209	100
2015	816	106	216	95
2016	836	206	389	164
2017	809	153	281	108
2018	700	182	288	117
2019	674	232	352	145
2020	729	209	293	105
2021	764	219	318	129
2022	802	258	368	139
2023	789	242	338	124
2024	807	267	365	124
2025	823	302	454	187

ХҮСНЭГТ 14.

МАЛЧДЫН НАСНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Малчдын бүлэг	насын	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Дүн		389	281	288	352	293	318	368	338	365	454
6-14			6								
15-34		85	79	75	77	55	62	67	67	71	73
35-54 насны эм, 35-59 насны эр		252	163	185	245	212	238	275	256	259	322
55 ба түүнээс дээш насны эм, 60 ба түүнээс дээш насны эр		52	33	28	30	26	18	26	15	35	59

ХҮСНЭГТ 15.

МАЛЧИН ӨРХИЙН СОЁЛ АХУЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

Өрхийн үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Цахилгаан гэрэлтэй	136	154	123	162	158	150	156	140	201	175
Телевизортой	135	121	108	153	146	141	129	127	189	180
Автомашинтай	357	259	267	324	405	590	429	453	448	459
Мотоциклтэй	39	36	64	70	67	108	97	87	168	86

ХҮСНЭГТ 16.

МАЛЫН ХАШАА, ХУДГИЙН ТОО

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Хашаа	1005	961	1058	970	897	1256	1079	938	1286	935
Худаг	206	203	234	195	246	239	238	377	293	218

ХҮСНЭГТ 17.

ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО

Он	Гахай	Үүнээс:Мэгж	Шувуу	Үүнээс: өндөглөгч
2007	4460	719	171692	112836
2008	5137	688	215354	177893
2009	6818	642	240915	157141
2010	8121	772	252069	181102
2011	5976	737	379971	310338
2012	5952	794	284729	269158
2013	6555	1042	240672	240570
2014	7901	1138	274887	274676
2015	5926	752	269307	218506
2016	5007	101	322527	318479
2017	4174	30	360722	250009
2018	3753	467	391542	360344
2019	3847	576	427437	349819
2020	3610	520	483300	401661
2021	4037	584	445390	376904
2022	3785	528	611826	435325
2023	848	163	529090	418846
2024	1437	351	511052	423728
2025	265	83	469613	389151

ХҮСНЭГТ 18.

ГАХАЙ, ШУВУУНЫ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮН

Он	Гахайн мах (тн)	Шувууны мах(кг)	Өндөг (мян.ш)
2007	15.8	78200.0	28209.0
2008	21.6	68600.0	45200.0
2009	60.0	56466.0	28593.3
2010	80.0	64855.0	37886.4
2011	216.3	226432.8	55438.0
2012	133.2	59900.0	42642.9
2013	199.2	69686.0	22239.3
2014	360.9	132642.0	48190.9
2015	37.0	89120.0	43238.3
2016	296.0	119630.0	55801.3
2017	88.2	91800.0	71957.3
2018	329.0	115800.0	111935.0
2019	322.5	127440.0	84424.0
2020	187.6	156745.0	105150.6
2021	167.0	210345.0	107226.9
2022	33.4	180590.0	102395.4
2023	2.8	164680.0	113316.0
2024	3.0	351700	95504.2
2025	1.6	171235	117131.3

ХҮСНЭГТ 19.

ГЭРИЙН ТЭЖЭЭВЭР НОХОЙ, МУУРНЫ ТОО, оноор

Он	Нохой		Муур	
	Бүгд	үүнээс: орон сууцанд	Бүгд	үүнээс: орон сууцанд
2008	4927	128	91	3
2009	4902	129	139	11
2010	4554	124	143	13
2011	4977	119	153	14
2012	5019	177	164	18
2013	5695	91	184	20
2014	5897	119	215	21
2015	5804	94	233	17
2016	5912	89	118	10
2017	5540	86	128	10
2018	5630	183	222	16
2019	5385	110	151	26
2020	5126	158	230	39
2021	4734	254	359	63
2022	4285	261	208	65
2023	3984	265	301	78
2024	3984	329	304	139
2025	4176	394	345	175

Хороо	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Нийт	5 804	5 912	5 540	5 630	5 385	5 126	4 734	4 285	3 984	3 984	4 176
1	21	13	22	24	23	21	31	32	32	33	33
2	37	37	28	33	15	20	23	19	19	18	18
3	13	13	13	55	19	31	37	21	28	27	27
4	350	316	320	257	300	300	299	209	156	208	93
5	439	455	456	420	420	328	325	263	281	279	219
6	500	475	473	353	360	370	325	382	360	325	272
7	321	371	351	354	299	220	199	203	155	181	206
8	822	761	753	786	572	547	601	599	556	552	505
9	802	752	752	798	765	750	661	612	545	504	527
10	458	628	634	505	499	499	316	299	265	250	246
11	105	75	72	41	39	11	11	5	11	13	13
12	402	434	121	396	461	409	471	358	426	421	484
13	494	585	590	513	399	421	516	387	429	392	397
14	483	544	527	561	667	619	242	219	163	274	598
15	23	26	23	30	3	3	64	58	39	44	43
16	534	427	405	504	494	494	514	493	343	289	254
17					7	28	33	37	50	27	48
18					8	10	16	24	24	19	19
19					20	27	27	27	28	43	53
20					8	9	14	8	11	11	6
21					7	9	9	6	10	10	37
22					-	-	-	5	5	5	5
23					-	-	-	4	6	23	20
24					-	-	-	5	34	24	41
25					-	-	-	10	8	12	12

ХҮСНЭГТ 21.

ГЭРИЙН ТЭЖЭЭВЭР МУУРЫН ТОО, хороогоор

Хороо	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Нийт	233	118	128	222	151	230	359	208	301	304	345
1	8	3	6	3	1	3	2	6	6	5	5
2	3	3	-	2	2	5	7	7	5	6	6
3	3	3	3	3	2	6	8	9	16	11	11
4	4	-	2	54	4	4	2	2	2	3	8
5	17	-	17	7	7	5	3	3	8	7	4
6	9	10	9	6	6	12	9	14	6	5	5
7	5	7	7	4	6	4	10	10	4	7	6
8	15	13	5	5	8	10	11	5	11	11	9
9	5	-	-	3	3	4	5	5	4	1	4
10	39	-	6	11	11	11	21	12	24	31	30
11	6	2	3	6	3	6	7	5	10	3	7
12	27	9	2	42	0	8	18	7	18	18	18
13	59	39	37	54	73	123	161	49	69	62	58
14	24	27	22	20	4	4	48	29	18	20	42
15	3	1	3	2	1	1	13	12	13	8	8
16	6	1	6	-	0	0	1	3	4	13	12
17	-	1	6	-	0	17	16	4	25	23	25
18	-	-	-	-	0	2	5	7	7	9	9
19	-	-	-	-	1	1	1	1	5	14	15
20	-	-	-	-	8	2	8	4	16	15	21
21	-	-	-	-	11	2	3	3	3	3	11
22	-	-	-	-	-	-	-	4	4	4	4
23	-	-	-	-	-	-	-	4	7	9	8
24	-	-	-	-	-	-	-	2	16	14	17
25	-	-	-	-	-	-	-	1	0	2	2

Статистик



Мэдээ, мэдээлэл



Номын сан



Мэдлэгээ шалгах
тоглоом



Валютын ханш



аппликейшнаас

СТАТИСТИКИЙН

мэдээллээ аваарай

Data lab

тооллого судалгааны
микро мэдээллийн сан



Social network



www.facebook.com/StatisticMongolia/



www.twitter.com/statistic_mn

Лавлах утас



1900-1212

Цахим шуудан



information@nso.mn